

БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХКӨЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ



СҮРЛЭГ БАЯН СУУДАЛ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ГАНЦЭЦЭГ



**ТЕХНИКИЙН УС ХАНГАМЖИЙН ЕРӨНХИЙ ШУГАМЫН АЛДАГДАЛ ТОДОРХОЙЛЖ,
ЗАСВАРЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ.**

20²³ оны 08-р сарын 28 өдөр

Дугаар.. 2023/70

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас Сүрлэг баян суудал ХХК-ийг төлөөлж захирал Д.Ганцэцэг /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйл, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Гүйцэтгэгч нь “Техникийн ус хангамжийн ерөнхий шугамын алдагдал тодорхойлж, засварлах” (цаашид “ажил” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан ажлыг, стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэн захиалагчид хүлээлгэн өгнө.

Хоёр. Ажил гүйцэтгэх хугацаа

2.1 Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 2023 оны 09-р сарын 15-ны өдрийн дотор багтаан хийж гүйцэтгэнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 18,020,800 /Арван найман сая хорин мянга найман зуу /-н төгрөг бөгөөд үнийн дүнд ажил гүйцэтгэхэд шаардлагатай бараа материал, тээврийн зардал, ажиллах хүчний зардал, тоног төхөөрөмж, НӨАТ бүгд орсон байна.
- 3.2 Захиалагчаас нийлүүлэгчид гэрээний үнийн дүнгийн 30% болох 5,406,240 /таван сая дөрвөн зуун зургаан мянга хоёр зуун дөч/-н төгрөгийн урьдчилгаа төлбөрийг гэрээ баталгаажсан өдрөөс ажлын 5 хоногт багтаан төлнө.
- 3.3 Үлдэгдэл төлбөрийг ажлыг хүлээлгэн өгсөний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 14 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Голомт банкны 1405167089 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь ажлыг хүлээн авахдаа техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа

Захиалагч:

1/4

Гүйцэтгэгч:

- төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг гүйцэтгэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-89000800
- 4.4 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Сүрлэг баян суудал ХХК-ийн инженер Б.Баярмагнай хариуцан ажиллана. Утас-99077633.

Тав. Ажил хүлээлцэх

- 5.1 Захиалагч, гүйцэтгэгч талуудаас комисс томилох актаар баталгаажуулан ажил хүлээлцнэ.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Гүйцэтгэгч нь ажлыг энэхүү гэрээний 2.1-т заасан хугацаанд бүрэн хүлээлгэж өгөөгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид албан ёсоор бичгээр өгнө. Гүйцэтгэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.
- 8.2 Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Гүйцэтгэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 Э.МӨНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

 Ө.УДВАЛ


АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.БАТТУЛГА

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА

 Э.АРИУНБОЛД

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН

 М.МОЛОМЖАВ


Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

СҮРЛЭГ БАЯН СУУДАЛ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ГАНЦӨЦЭГ



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, 24-р хороо,
наадамчдын зам, 617-р байр 5 тоот
Утасны дугаар: 99077633
РД: 8386536

Захиалагч: 

3/4

Гүйцэтгэгч: 

БАТЛАВ

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫН ЕРӨНХИЙ

ИНЖЕНЕР *Е.Гадаг* Э.МӨНХЖАРГАЛ

ТЕХНИКИЙН УС ХАНГАМЖИЙН ЕРӨНХИЙ ШУГАМЫН АЛДАГДАЛ
ТОДОРХОЙЛЖ, ЗАСВАРЛАХ АЖЛЫН ЭЗЭЛХҮҮН

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1.	Худаг №7-с хойш 20-100 метр шугамыг 2 метрийн өргөнтэй 3-4 метр гүн ухаж, ил гаргах, гэмтлийг тодорхойлох. /Зориулалтын багажаар алдагдлыг тодорхойлох./	М	20-100
2.	Ажил эхлээд дуусах хүртэлх хугацаанд ухсан сувгийн усыг соруулж зайлуулах. /Бүтээмж 50м ³ /цаг 2 ширхэг гном насос суурилуулах./	ш	2
3.	Цоорсон шугамыг наах. /Ду159мм/	ш	2
4.	Техникийн ус хангамжийн 2-р шугамыг даралтанд оруулж шалгах /Худаг №4,5-н гүний насосыг ажилд залгаж 4-8 ага даралтанд оруулж шалгах./	ком	1
5.	Усан шахалт хийсний шугамд үзлэг хийж, хэвийн байвал шугамыг булаах.	МЗ	150
6.	Худгийн шугам хоолой, худаг засварласан акт, тайлан хүлээлгэн өгөх.		

БОЛОВСРУУЛСАН:

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА

Э.Ариунболд Э.АРИУНБОЛД

АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР

Л.Эрдэнэхүү Л.ЭРДЭНЭХҮҮ